

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР,
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2008 оны ⁰³ дугаар сарын ⁰⁷ ны өдөр

Дугаар ¹²⁹ ²⁷

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Галын аюулгүй байдлын тухай" хуулийн 16 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. Дүрмийг мөрдөж ажиллахыг Шүүхийн шинжилгээний байгууллагын нийт алба хаагчдад үүрэг болгосугай.

3. Галын аюулгүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн хэлтэс, товчоо, албадын дарга, байгууллагын галын сайн дурын комисс, гал түймрийн хяналтын улсын байцаагч нарт даалгасугай.





ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨМЖЭЭНД ДАГАЖ МӨРДӨХ ГАЛЫН АЮУЛГҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийг Шүүхийн шинжилгээний үндэсний төв түүний харъяа хэлтэс, товчоо, тасаг, албад дагаж мөрдөнө.

1.2. Энэ дүрэм нь шүүхийн шинжилгээний байгууллагын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангуулахад чиглэгдсэн үндсэн шаардлагыг тодорхойлно.

1.3. Дүрмийн хэрэгжилтэд шүүхийн шинжилгээний үндэсний төвийн хэлтэс, товчоо, албадын дарга, галын сайн дурын орон тооны бус инженер техникийн комисс, гал түймрийн улсын хяналтын эрх бүхий байцаагч нар хяналт тавьж ажиллана.

Хоёр. Галын аюулгүйн ерөнхий шаардлагууд

2.1. Шүүхийн шинжилгээний үндэсний төв, түүний харъяа хэлтэс, товчоо, албад галын аюулгүй байдлыг хангуулах талаар дараах шаардлагыг хэрэгжүүлнэ.

2.1.1. байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж нь галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон "Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал" /БНБД 21-01-02/, "Цахилгааны галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага" /MNS53.90.2004/, "Аж ахйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм" /MNS55.66.2005/ стандартын дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан байна.

2.1.2. гал түймэр болон аваар ослын үед хүн, эд материалыг аврах зам гарцын схем зургийг хийж, хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулах, зам гарцыг байнга чөлөөтэй байлгах.

2.1.3. аваарын бүх хаалга нь гадагш чиглэлтэй чөлөөтэй нээгддэг байхаас гадна хэдийд ч ашиглахад бэлэн байлгах.

2.1.4. байгууллагын байрны цахилгааны шугам сүлжээний тавилыг цахилгаан угсралт ашиглалтын дүрмийн дагуу схем гарган хийсэн байх.

2.1.5. байгууллагын байрны цахилгаан хуваарилах самбарт стандартын шаардлага хангасан гал хамгаалагч хэрэглэх.

2.1.6. агааржуулалтын болон халаалтын систем, цахилгаан хуваарилах самбар, хөдөлгүүр барилгын дүрэм нормын шаардлагад нийцсэн байх ба жилд хоёроос доошгүй удаа үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийсэн байх.

2.1.7. барилга байгууламж нь аянга зайлуулагчтай, цахилгаан хөдөлгүүр, тоног төхөөрөмжүүд газардуулгатай байх ба газардуулгын биеийн масс, утасны хөндийрүүлэгчийн эсэргүүцэлд жил тутам хэмжилт хийлгэн эвдрэл гэмтлийг тухай бүр засах.

2.1.8. байгууллагын цахилгаан тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, найдвартай ажиллагааг улирал тутам шалгаж, хэвийн ажиллагааг хангуулах.

2.1.9. барилга байгууламж руу очих гал унтраах автомашины зам гарцыг ямагт чөлөөтэй байлган хэрэв энэ зам гарцыг хаах шаардлага гарвал тэр тухайгаа гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдсэн байх.

2.1.10. байгууллагын ажлын хэрэгцээний автомашинууд гал унтраагууртай, ажил үйлчилгээнд гарахад нь галын аюулгүй байдлыг хангуулсан байх.

2.1.11. алба хаагчид гал түймэр гарсан үед унтраах анхан шатны мэдлэг, багаж хэрэглэх дадлага эзэмшсэн байх.

2.1.12. төвийн даргын тушаалаар байгууллагын галын аюулгүй байдлыг хангуулах үүрэг бүхий галын сайн дурын орон тооны бус инженер техникийн комисс томилон ажиллуулж, удирдлага зохион байгуулалтаар хангах.

2.1.13. орон тооны бус комиссын ахлагч нь тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөтэй байж, мэргэжил, хяналтын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Гурав. Шүүхийн шинжилгээний байгууллагын албан тушаалтны эрх, үүрэг

3.1. Төвийн харъяа хэлтэс, товчоо, тасаг, албаны дарга, галын сайн дурын орон тооны бус инженер техникийн комисс нь галын аюулгүй байдлыг хангуулах зорилгоор дараах эрх, үүрэгтэй байна.

3.1.1. галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх.

3.1.2. барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх болон хийц, бүтээц, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлахдаа гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагад мэдэгдэж, холбогдох зөвшөөрөл авч мэргэжлийн дүгнэлт гаргуулах.

3.1.3. гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн мэргэжлийн байгууллагын туслалцаатайгаар гал түймэр, аваар осол гарсан үед хүн, эд материалыг аврах шуурхай төлөвлөгөө гаргаж, түүний дагуу ажиллах нөхцлийг хангах.

3.1.4. алба хаагчдад гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3.1.5. галын аюулаас урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах зардал төсвийг жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусган гал унтраах багаж хэрэгслийг нормативын дагуу бэлтгэж байнгын бэлэн байдалд байлгах.

3.1.6. шаардлагатай телефон утасны дугаар болон албан тушаалтан, алба хаагчдын хаягийн бүртгэлийг жижүүр дээр бэлэн байлгана.

3.1.7. гал унтраах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

Дөрөв. Гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

4.1. Гал түймрийн улсын хяналтын байцаагч дараах эрх, үүрэгтэй байна.

4.1.1. галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, энэ дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулах.

4.1.2. хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, танилцуулга, албан шаардлага, тоо баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

4.1.3. галын аюулгүй байдлыг хангуулахтай холбогдсон журам, заавар боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

4.1.4. галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага бичих, биелэлтийг хангуулах, хариуцлага тооцох.

4.1.5. байгууллага, албан тушаалтнаас гал түймрийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон баримт, бичиг, мэдээ, материалыг шаардан гаргуулж авах

Тав. Хориглох зүйл

5.1. Байгууллагын барилга байгууламж, түүний хийц бүтээц, өрөө тасалгааны зохион байгуулалтыг батлагдсан зураг төсөлгүй өөрчлөх.

5.2. Аврах зам, гарц, хаалга, шат, хонгил, гэгээвч, шатны талбайг хааж таглах, эд зүйл хураах.

5.3. Шатамхай шингэн, тэсэрч дэлбэрэх аюултай бодис, баллонтой хий зэрэг галын аюултай материалыг зөвшөөрөлгүйгээр өрөө тасалгаа, газар доорх давхарт хадгалах, хэрэглэх.

5.4. Цахилгааны шугам сүлжээний гэмтэлтэй төхөөрөмж хэрэглэх.

5.5. Гэрэлтүүлэг, чийдэнг шатамхай зүйлээр ороох, бүрхүүлийг авч хаях.

5.6. Компьютер, телевизор, хөгжим, плитка, ус буцалгагч, цахилгаан халаагуур зэрэг хэрэгслийг хариуцах хүнгүйгээр залгаатай орхих.

5.7. Стандартын бус цахилгаан хэрэгсэл, шаардлага хангахгүй гал хамгаалагч бусад богино холболт, хэт ачаалаллаас хамгаалах хэрэгслийг хэрэглэх.

5.8. Цахилгааны мэргэжлийн бус хүнээр засвар үйлчилгээ, угсралтын ажил гүйцэтгүүлэх.

5.9. Агаар салхивчийн системийн өрөөний хаалгыг нээлттэй орхих, сорох суваг, нүх, торыг хаах.

5.10. Гал унтраах багаж хэрэгсэлийг зориулалтын бус зүйлд ашиглах.

5.11. Байгууллагын барилга байгууламжид зөвшөөрөлгүй гагнуурын ажил хийх, ил гал гаргах, зөвшөөрөгдөөгүй газар тамхи татах.